



# ГАЛТ ТЭРЭГНИЙ ХӨДӨЛГӨӨН ЗОХИЦУУЛАЛТЫН НЭГДСЭН ТӨВ



E-NEWSLETTER

- [f facebook.com/Rtcc.mn](https://facebook.com/Rtcc.mn)
- [g http://rtcc.mrtd.gov.mn](http://rtcc.mrtd.gov.mn)
- [✉ info@rtcc.mrtd.gov.mn](mailto:info@rtcc.mrtd.gov.mn)
- [☎ +976 77244409](tel:+97677244409)

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТОВЧ ТАЙЛАН  
2019 оны хагас жилийн дугаар



## Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд саналаа тусгууллаа



23, зарим зүйл, хэсэг, заалт, дэд заалтыг өөрчлөн найруулах нийт 205 саналыг нэгтгэж 2019.02.20-ны албан бичгээр болон цахим шуудангаар ЗТХЯ-нд хүргүүлсэн бөгөөд хэлэлцүүлгийн явцад саналаа дэвшүүллээ.

Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн олон нийтийн хэлэлцүүлэг 2019.02.26-нд төмөр замын соёлын ордонд боллоо. Тус хэлэлцүүлэгт төвөөс хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд нэмэлтээр тусгах



“Төрөөс тээвэр логистикийн талаар баримтлах бодлого боловсруулах” ажлын хэсгийн анхны хуралдаан боллоо.

Зам тээврийн хөгжлийн сайдын тушаалаар байгуулагдсан “Төрөөс тээвэр логистикийн талаар баримтлах бодлого боловсруулах” үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орж ажиллан “ОСЖД-ын оруудын логистикийн бодлого”-ыг судлан, ажлын хэсгийн төлөвлөгөөнд тусгах саналаа ЗТХЯ-ны ТЗДТБХЗГ-т хүргүүлсэн.



„Цацраг идэвхт материалыг тээвэрлэх аюулгүй ажиллагааны дүрэм“ төсөлд саналаа хүргүүллээ.

Зам, тээврийн хөгжлийн яамнаас ГТХЗНТ-д ирүүлсэн албан бичгийн дагуу „Цацраг идэвхт материалыг тээвэрлэх аюулгүй ажиллагааны дүрэм“-ийн төсөлд санал боловсруулж албан бичгээр хүргүүлсэн.





Төмөр замын салбарын мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх, мэргэжлийн боловсрол, сургалтын тогтолцоог сайжруулахаар Зам, тээврийн хөгжлийн яамтай хамтран ажиллалаа.

ЗТХЯ-ны ТЗДТБХЗГ-ын дарга А. Батболд, ахлах мэргэжилтэн Ж. Булганхүү, ТМССХ-ийн дарга Б. Энхжаргал, “МТЗ” ТӨХК-ийн хуульч н. Удвал нарын хамт салбарын мэргэжилтний мэргэшлийн зэрэг олгохтой холбоотой Төмөр замын тээврийн тухай шинэчилсэн хуулийн төсөлд санал боловсруулан хамтарч ажилласан. Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд салбарын мэргэжилтэй ажилтан болон мэргэжилтний мэргэжлийн боловсрол, сургалтын асуудлаар хуулийн 1 зүйл 5 заалт болгон оруулахаар саналаа тусгуулсан.



Салбарын мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэх, мэргэжлийн боловсрол, сургалтын тогтолцоог сайжруулах МБСҮЗөвлөлийн дэргэд яамны ТНБ-ийн даргаар ахлуулсан Зам, тээврийн салбар зөвлөл байгуулагдаж МБСҮЗ-өөс зохион байгуулагдсан “салбар зөвлөл болон дэд салбар зөвлөлийн гишигдийг чадавхжуулах уулзалт, хэллэлцүүлэг”-т оролцож санал солилцлоо.





## Төмөр замын тээврийн салбарын статистик мэдээний нэгдсэн санг бүрдүүлэн ажиллаж байна

Төмөр замын байгууллагууд харилцан мэдээлэл солилцох журмыг хэрэгжүүлж төмөр замын салбарын мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх, хөтлөх, боловсруулах, ашиглах үйл ажиллагааг хариуцан хоног, 7 хоног, сар, улирлын мэдээг тогтоосон хугацаанд мэдээллийн санд тогтмол бүрдүүлэн ажиллаж байна.

“Тээврийн салбарын 2018 оны эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн биелэлт”, Төмөр замын төрийн захиргааны статистик мэдээг Т3-1, Т3-2, Т3-3, Т3-4, Т3-5 маягтын дагуу суурь бүтцүүдээс авч нэгтгэн боловсруулан 2018 жилийн эцсийн байдлаар, Үндэсний статистикийн хорооны даргын 2009 оны 10/92 дугаар тушаалаар батлагдсан улсын тайлан Т-9 маягтын дагуу төмөр замын тээврийн тээвэрлэлтийн мэдээг сар бүр Зам, тээврийн хөгжлийн яамны Төмөр зам, далайн тээврийн бодлогыг хэрэгжүүлэх газар, Бодлого төлөвлөлтийн газарт хүргэж танилцуулсан.


**ГАЛТ ГӨРӨЛТИЙН  
ХОДОЛОГДОН ХОЖИХДАЛЫН  
ЮЛСЫН ТӨВ**

17040 Улаанбаатар хот, Улсын төхөөрөмжийн урсацны зорилтуудын төхөөрөмжийн цахим хүчинтэй багасгалахад зориулахад зориулсан 6 дундаж дэхэр  
**209/01/14 № 19**  
Төслийн № \_\_\_\_\_

ГЭМ ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМНЫ ТӨМӨР ЗАМ, ДАЛАИН ТЭЭВРИЙН БОДЛОГЫН ХӨРӨЛГҮҮЛТИЙН ЗОХИУУЛАХ ГАЗАР, БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТИЙН ГАЗАР

Ундэсний статистикийн хорооны даргын 2009 онц 01/92 дугаар тушаалаар батлагдсан улсын тайлан Т-9 маягтын дагуу төмөр замын тээврийн 2018 оны архивчирдаар сарын тээвэрлэлтийн мэдээг хүргүүлж байна.


Хувьслалт / худастай  
*[Signature]*  
ЗАХИРАЛ *[Signature]* ГАЛТ ГӨРӨЛТИЙН ХОДОЛОГДОН ХОЖИХДАЛЫН ЮЛСЫН ТӨВ  
000368




2019 оны 1-6 дугаар сарын статистик мэдээ, мэдээллийг нэгтгэж нийгэм, эдийн засгийн байдалд нөлөөлсөн байдлаар буюу төмөр замын ачаа болон зорчигч тээвэрлэлт, ачаа ачилт, зорчигч болон ачаа эргэлт, дамжин өнгөрсөн болон тээвэрлэсэн ачаа, галт тэрэгний зурмагийн биелэлтэд дүн шинжилгээ хийж, ЗТХЯ-ны [www.mrtd.gov.mn](http://www.mrtd.gov.mn), төвийн [www.rtc-c.mrtd.gov.mn](http://www.rtc-c.mrtd.gov.mn) цахим хуудаст инфографик хэлбэрээр байршуулан олон нийтэд нээлттэй ил тод мэдээллээ.

Зам, тээврийн хөгжлийн яамны ТЗДТБХЗГ-т “Төмөр замын тээврийн тухай хуулийн шинчилсэн найруулгын төсөл”-д хийх үнэлгээний тоо баримтад шаардагдах мэдээллийг гарган цахим хэлбэрээр хүргүүлсэн.


## Тэмэр замын тээврийн үндсэн үзүүлэлт



Зорчигч тээврэлт 2019 оны зургаадугаар сард 261.5 мян.зорчигч тээвэрлэсэн, ачаа тээврэлт 2019 оны зургаадугаар сард 2220.7 мян.тн ачаа тээвэрлэсэн байна.

Ачилт- ачааны төрлөөр  
/2019 оны 6 дугаар сард/

## Дамжин өнгөрсөн ачаа /мян.тн/





Дамжин өнгөрсөн ачаа 2019 оны зургаадугаар сард 393.8 мян.тн тээвэрлэсэн байна.

Ачилтаар 2019 оны зургаадугаар сард төмрийн худэр, нүүрс, барилгын материал, жонш, зэс, молибдений баяжмал, хар төмөр өссөн үзүүлэлттэй байна. Нийт 1607.4 мян.тн ачсан байна.

Төмрийн худэр	34%
Нүүрс	33%
Барилгын материал	14%
Бусад ачаа	10%
Жонш	4%
Хар төмөр	2%
Зэс, молибдений баяжмал	3%

2019 оны 6 дугаар сард өссөн дүнгээр зорчигч тээвэрлэлт 1237.8 мян.зорчигч тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 2.2%-иар буурсан, ачаа тээвэрлэлт нь 13161.4 мян.тн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 7.8%-иар өссөн үзүүлэлттэй байна.

## ИНФОГРАФИК





"Төмөр замын байгууллагууд харилцан мэдээлэл солилцох журам"-ыг олон нийтэд танилцуулан, сурталчлах арга хэмжээ зохион байгуулгадлаа.


"Төмөр замын байгууллагууд харилцан мэдээлэл солилцох журам"-ыг олон нийтэд танилцуулан сурталчлах хэрэгжилтийг хангах, статистик мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх, хөтлөх, хадгалах, ашиглахтай холбогдсон төр, хувийн хэвшлийн оролцоо, хамтын ажиллагаа, зохион байгуулалтыг сайжруулах, салбарын байгууллагууд хоорондоо мэдээллийг хэрхэн солилцох, салбарын мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх цахим орчинг сайжруулж шинэчлэн зохион бүтээх хэлэлцүүлэг арга хэмжээг зохион байгуулж, шинэчлэн батлагдсан журмын танилцуулга хийлээ.

Арга хэмжээнд ЗТХЯ-ны төлөөлөл, YСХ-ны тээврийн салбарын статистик болон суурь бүтэц эзэмшигч байгууллагуудын удирдлагууд болон хилийн өртөөдийн товарын конторын эрхлэгч нар оролцож салбарын статистик бүртгэл мэдээлэлд тулгамдаж буй асуудлын талаар саналаа солилцож төвийн зүгээс цаашид зөвлөмж гарган ажиллахаар боллоо.



**NEWS** Галт тэрэгний хөдөлгөөний 2019 оны зуны нэгдсэн зурмаг боловсруулж баталлаа.

Галт тэрэгний хөдөлгөөний зуны нэгдсэн зурмагийг боловсруулан, баталгаажуулан, хуулбарыг ЗТХЯ болон "УБТЗ" ХНН, "БТЕГ" ХХК, "МТЗ" ТӨХК зэрэг төмөр замын суурь бүтэц эзэмшигч байгууллагуудад хүргүүлэн мөрдөн ажиллаж байна.





Монгол Улсын хилээр нэвтэрч буй хөдлөх бүрэлдэхүүнд дугаар олгож, мэдээллийн нэгдсэн санд бүртгэж байна.

“УБТЗ” ХНН-ын 1 зүтгүүр, „Төмөр замын зураг төслийн институт“ ХХК-ийн 28 ачааны хагас вагон, “Эрдэнэт үйлдвэр“ ТӨҮГ-ын 2 думкар, “МАК ЦЕМЕНТ“ ХХК-ийн 19-7075 загварын цементийн 50 хоппер нийт 85 хөдлөх бүрэлдэхүүнд дугаар олгосон.

ГХЭНТ									
	Ном	Тайлбар	Олон удаан	Сонирхуулсан	Багасгын	Төхөн	Чадалыгийн	Хамгаалалт	Инженерийн
<i>Нийтийн төслийн институтын хөдлөх бүрэлдэхүүнүүдийн тайлбар</i>									
1	3479	940027 нийтийн БЕСЛЯ	24	4	23,5	1,8Мт	10	88	22
2	4031	940048 нийтийн БЕСЛЯ	24	4	23,5	1,8Мт	10	88	22
3	248	940065 нийтийн БЕСЛЯ	24	4	23,5	1,8Мт	10	88	22
4	4032	940076 нийтийн БЕСЛЯ	24	4	23,5	1,8Мт	10	88	22
5	3817	940078 нийтийн БЕСЛЯ	24	4	23,5	1,8Мт	10	88	22
6	4000	940085 нийтийн БЕСЛЯ	24	4	23,5	1,8Мт	10	88	22
7	4033	940094 нийтийн БЕСЛЯ	24	4	23,5	1,8Мт	10	88	22
8	3919	940102 нийтийн БЕСЛЯ	24	4	23,5	1,8Мт	10	88	22
9	4001	940103 нийтийн БЕСЛЯ	24	4	23,5	1,8Мт	10	88	22
10	3902	940105 нийтийн БЕСЛЯ	24	4	23,5	1,8Мт	10	88	22
11	4000	940106 нийтийн БЕСЛЯ	24	4	23,5	1,8Мт	10	88	22
12	4034	940107 нийтийн БЕСЛЯ	24	4	23,5	1,8Мт	10	88	22
13	4040	940104 нийтийн БЕСЛЯ	24	4	23,5	1,8Мт	10	88	22
14	4032	940105 нийтийн БЕСЛЯ	24	4	23,5	1,8Мт	10	88	22
15	3919	940106 нийтийн БЕСЛЯ	24	4	23,5	1,8Мт	10	88	22
16	4000	940107 нийтийн БЕСЛЯ	24	4	23,5	1,8Мт	10	88	22
17	4000	940108 нийтийн БЕСЛЯ	24	4	23,5	1,8Мт	10	88	22
18	3902	940109 нийтийн БЕСЛЯ	24	4	23,5	1,8Мт	10	88	22

Хөдлөх бүрэлдэхүүн бүртгэлийн програмд нийт 280 вагоны мэдээллийг 16 өгөгдлийн дагуу бүртгэн оруулж, Суурь бүтцийн бүртгэлийн програмд “УБТЗ” ХНН -ийн Замын 1-р ангийн 17 өртөө зөрлөгийн, замын 6-р ангийн 7 өртөөний, замын 2-р ангийн 5 өртөө зөрлөг, БТЕГ ХХК-ийн 3 өртөө зөрлөгийн нийт 366 салбар замуудыг бүртгэлд хамруулав.




Төрийн болон төрийн бус байгууллагууд, аж ахуй нэгжүүдийн хөдлөх бүрэлдэхүүнд улсын нэгдсэн тооллого, бүртгэл хийлээ.

Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн 128 тоот тушаалаар байгуулагдсан хөдлөх бүрэлдэхүүний бүртгэл тооллогын комисс нь өмчийн хэлбэр харгалзахгүйгээр төмөр замын тээврийн салбарын тээвэрлэлтийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа болон ашиглагдаагүй хөдлөх бүрэлдэхүүнийг бодит байдалтай нь тулган, тооллого хийж дүгнэлт гарган ажиллалаа.



МОНГОЛЫН ТӨМӨР ЗАМ





Стандартын төслийн орчуулга, баримт бичгийг орчуулан боловсруулж байна.

“ТВ 10031-2009 Төмөр замын ачааны вагон үйлдвэрлэл, засвар барилга байгууламжийн зураг төслийн шаардлага” стандартыг орчуулан боловсруулж 2019 оны 03 сарын 19-нд Стандарт хэмжилзүйн газрын даргын тушаалаар батлуулсан.

“ГОСТ 33435-2015 Төмөр замын хөдлөх бүрэлдэхүүний аюулгүй байдлыг хангах удирдлага, хяналтын төхөөрөмж, Аюулгүй байдалд тавигдах шаардлага, хяналтын арга”, “О+Р 941 Төмөр замын мэдээллийн сан, мэдээлэл харилца холбооны дэд бүтцийн аюулгүй байдал”, “ISO 6346 Ачааны чингэлэг-Кодчилол, нэгдсэн дугаарлалт, тэмдэглэгэ” стандартыг орчуулан боловсруулж, төсөлд төмөр замын байгууллагуудаас ирүүлсэн саналыг нэгтгэж, төсөлд тусган ажиллаж байна.



Тээврийн логистикийн систем дэхь хөдлөх бүрэлдэхүүний чингэлгийн хөдөлгөөнийг хянах технологийн судалгаа хийж байна.

Зам тээврийн хөгжлийн сайдын 129 тоот тушаалаар “ГТХЗНТ” УТҮГ-ын захирал А. Буюннэмэхээр ахлуулсан 17 гишүүнтэй ажлын хэсэг 2019 оны 4 дүгээр сарын 30-нд байгуулагдсан.

Ажлын хэсэг нь хөдлөх бүрэлдэхүүнийг хянах орчин үеийн технологи болон түүнийг үйлдвэрлэлд нэвтрүүлэх боломжийн талаар судалгаа хийж, төсөл боловсруулан 2019 оны 9 дүгээр сард Зам, тээврийн хөгжлийн яамны Шинжлэх ухаан технологийн зөвлөлөөр хэлэлцүүлэхэд бэлэн болголоо.

Төслийн хүрээнд БНХАУ-ын Харбин хотын төмөр замын судалгааны институтийн үйл ажиллагаатай очиж танилцан, судлаач эрдэмтдийг урьж 2019 оны 07 дугаар сарын 03-ны өдөр Төмөр замын дээд сургууль дээр төмөр замын салбарын инженер техникийн ажилтнуудыг оролцуулан санал солилцон, мэдлэг туршлагаа хуваалцсан хэлэлцүүлгийг зохион байгуулсан. Мөн ОХУ-ын Эрхүү хотын зам харилцааны улсын их сургууль, Төмөр замын эрдэм шинжилгээний төв, Дорнод Сибирийн галт тэрэгний хөдөлгөөн удирдах төвтэй танилцаж хөдлөх бүрэлдэхүүний хөдөлгөөнийг хянах технологийг нэвтрүүлсэн арга туршлагаас судалсан.






## Төвийн архивын баримтад нэгдсэн тооллого хийж, бүртгэлжүүлэв.

ГТХЗНТ-ийн 2019 оны үр дүнгийн гэрээ, үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан архив, албан хэрэг хөтлөлт, төрийн байгууллагын ажлын зохион байгуулалтад улсын үзлэг хийх бэлтгэл ажлыг хангах арга хэмжээний төлөвлөгөөний дагуу төвийн захирлын 2019 оны А/18 дугаар тушаалаар батлагдсан ажлын комисс төвийн архивын баримтад нэгдсэн тооллого хийж, бүртгэх ажлыг зохион байгуулав.



## Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4 дэх хэсэг, Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журамд заасан мэдээллийг төвийн цахим хуудас болон Шилэн дансны цахим хуудсанд байршуулан мэдээлж байна. Шилэн дансны цахим хуудаст байршуулах мэдээллийг цаг тухай бүрт тайлагнан ажиллаж байна.



The screenshot shows the GATT portal's interface. At the top, there are several menu items in Russian: ГОСУДАРСТВЕННАЯ СЕРВИСНАЯ ПЛАТФОРМА, НАЧАЛО, АДМИНИСТРАЦИЯ, ТОРГОВЫЙ ФОРМАТОВЫЙ КОДКНИК, ПОДДЕРЖКА, ИНФОРМАЦИОННЫЙ ЦЕНТР, and ДЛЯ ПРЕДПРИЯТИЙ. Below the header, a banner reads 'Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна.' On the left, there is a sidebar with a logo for 'Чиньийн эмчилгээний төслийн тухай' and a link to 'Чиньийн эмчилгээний төслийн тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна.' The main content area displays a table with columns for 'Номер документа', 'Название документа', 'Установленные сроки', 'Текущий документ', 'Изменения', and 'Статус'. The table lists 9 documents, each with a status column showing various icons like checkmarks, crossed-out checkmarks, and question marks.

Номер документа	Название документа	Установленные сроки	Текущий документ	Изменения	Статус
1	Доржийн төслийн тухай [бүтэц ижтэй]	2019.1.19 2019.2.19 2019.3.19	2019.1.19 2019.2.19 2019.3.19 2019.4.19 2019.5.19 2019.6.19 2019.7.19 2019.8.19 2019.9.19 2019.10.19 2019.11.19 2019.12.19	- - - -	+
2	Төслийн байгуулалтын бичигийн тасал, түүхтэй, көрьеэний хамгаалалтад барьж хамгийн дундажийн хувь [бүтэц ижтэй]	2019.1.19 2019.2.19 2019.3.19	2019.1.19 2019.2.19 2019.3.19 2019.4.19 2019.5.19 2019.6.19 2019.7.19 2019.8.19 2019.9.19 2019.10.19 2019.11.19 2019.12.19	+	+
3	Түүхийн тасалыг орж хөгж, ирвээж [түүхий]	2019.1.19 2019.2.19 2019.3.19	2019.1.19 2019.2.19 2019.3.19 2019.4.19 2019.5.19 2019.6.19 2019.7.19 2019.8.19 2019.9.19 2019.10.19 2019.11.19 2019.12.19	+	+
4	Онцгой төслийн зорилтуудын хөтөлбөр, тусган уламжлалын зорилтуудыг зарцуулсан төслийн [бүтэц ижтэй]	2019.1.19 2019.2.19 2019.3.19	2019.1.19 2019.2.19 2019.3.19 2019.4.19 2019.5.19 2019.6.19 2019.7.19 2019.8.19 2019.9.19 2019.10.19 2019.11.19 2019.12.19	+	+
5	Хөндө, тусгамшийн хамса, түүний зорилтуудын төслийн [бүтэц ижтэй]	2019.1.19 2019.2.19 2019.3.19	2019.1.19 2019.2.19 2019.3.19 2019.4.19 2019.5.19 2019.6.19 2019.7.19 2019.8.19 2019.9.19 2019.10.19 2019.11.19 2019.12.19	+	+
6	Шинжилгээний зорилтуудын төслийн тасал, түүхтэй, көрьеэний хамгаалалтад барьж хамгийн дундажийн хувь [түүхий]	2019.1.19 2019.2.19 2019.3.19	2019.1.19 2019.2.19 2019.3.19 2019.4.19 2019.5.19 2019.6.19 2019.7.19 2019.8.19 2019.9.19 2019.10.19 2019.11.19 2019.12.19	+	+
7	Санкхүүгийн төслийн [бүтэц ижтэй]	2019.1.19 2019.2.19 2019.3.19	2019.1.19 2019.2.19 2019.3.19 2019.4.19 2019.5.19 2019.6.19 2019.7.19 2019.8.19 2019.9.19 2019.10.19 2019.11.19 2019.12.19	+	+
8	Санкхүүгийн төслийн хийж түрүүлж друот [бүтэц ижтэй]	2019.1.19 2019.2.19 2019.3.19	2019.1.19 2019.2.19 2019.3.19 2019.4.19 2019.5.19 2019.6.19 2019.7.19 2019.8.19 2019.9.19 2019.10.19 2019.11.19 2019.12.19	+	+
9	Байгуулалтын бичигийн төслийн [бүтэц ижтэй]	2019.1.19 2019.2.19 2019.3.19	2019.1.19 2019.2.19 2019.3.19 2019.4.19 2019.5.19 2019.6.19 2019.7.19 2019.8.19 2019.9.19 2019.10.19 2019.11.19 2019.12.19	+	+

# Мэдээ, мэдээлэл



“ТРАНЗИТ МОНГОЛ - 2019” форумд төвийн удирдлага болон мэргэжилтнүүд оролцлоо.

Монгол Улсын Засгийн газар, Зам тээврийн хөгжлийн яам, Монгол Оросын хувь нийлүүлсэн “Улаанбаатар төмөр зам” ХНН хамtran зохион байгуулсан “ТРАНЗИТ МОНГОЛ - 2019” форумд төвийн удирдлага болон мэргэжилтнүүд оролцлоо.



“УБТЗ” ХНН-ийн “Нөөц, инноваци, хөгжил” сэдэвт шинэ бүтээл ашигтай загварын үзэсгэлэнд оролцлоо.



“УБТЗ” ХНН-ээс 2019 оны 04 сарын 25-ны өдөр зохион байгуулсан “Нөөц, инноваци, хөгжил” сэдэвт үзэсгэлэнд төвийн мэргэжилтнүүд оролцож суурь бүтцийн ШБАЗын талаар мэдээлэл авч танилцуулга материалыг төвийн сургалтын танхимд байршууллаа.



Төмөр замын холбогдолтой гадаад улсын сэтгүүлийг төвийн цахим хуудсанд байршууллаа.

Гадаад орнуудын төмөр замын салбартай холбоотой сэтгүүлийн 1-6-р сарын дугаарыг харах болон татаж авах форматад хөрвүүлэн төвийн [www.rtcc.mrtd.gov.mn](http://www.rtcc.mrtd.gov.mn) цахим хуудсанд байршуулж, олон нийтэд хүргэлээ.

Railways ILLUSTRATED  
Heritage Gala Season  
What's on and where!  
PLUS Delta to Cleethorpes  
Fife loop-busted  
British's Depots  
Crewe Electric  
Gavia Thameslink introduces Class 717s  
GBRf 50s roll-out  
Class 70 driver training starts  
WEST SOMERSET RAILWAY REOPENS TO MINEHEAD

The RAILWAY Magazine  
BRITAIN'S BEST-SELLING RAIL TITLE  
DfT throws out Stagecoach franchise bids  
■ Abellio wins East Midlands  
■ Pensions issue puts bids in doubt  
■ Virgin Trains name to disappear?  
■ New delay for Crossrail  
THE LINE BR COULD NOT CLOSE STEAM ERA COALING TOWERS BUILDING ON BROADBRAKE GWSR'S RECORD YEAR  
WEST SOMERSET RAILWAY REOPENS TO MINEHEAD

SPECIAL ISSUE: Celebrating the first transcon  
Trains  
150 years!  
Golden Spike's big anniversary  
Promontory by the hour  
Two famous locomotives  
In focus: 'Champagne picture' analysis  
MAY 10, 1869  
MAP Find out where your favorite railroad was completed  
BONUS CONTENT CODE PG. 4



 8-р давхар, Хан-Уул цамхаг,  
Б.Шаравын гудамж 6,  
3-р хороо, Хан-Уул дүүрэг,  
Улаанбаатар хот 17042, Монгол Улс

